

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн,
үр нөлөө*

АУДИТЫН КОД: БУА-2025/31-04-ШТА-ГА

**БУЛГАН АЙМАГ
2025 ОН**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Open.audit.mn

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ОНХС-аас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг	
Хүснэгт 2	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт	
Хүснэгт 3	Аймаг, суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зөрчил	
Хүснэгт 4	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа	
Хүснэгт 5	ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт	

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлтэд	
Дүрслэл 2	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ангилал	

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн хуваарь, санхүүжилтийн гүйцэтгэл	
Хавсралт 2	ОНХС-гийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийн зөрчлийн шийдвэрлэлт	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай” А/108 “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ▪ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ зэрэг байгууллагууд болон холбогдох бусад байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт <i>MNS 6817-3:2020 “Төрийн аудит. Чанарын хяналт”</i> , <i>MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”</i> , <i>MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”</i> , <i>MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”</i> -ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж,

аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/,
- Төсвийн тухай хууль,
- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

**Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Д.Анхбаяр, аудитор Б.Энхтөр нар 2024 оны 05 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж

**Ерөнхий
мэдээлэл:**

заасан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар ОНХНС болон улсын төсвөөс Булган аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 14,228.4 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн “Удирдлагын мэдээллийн систем”-ийг Сангийн яамны сайтад байршуулсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл 3,618.1 сая төгрөг, ОНХНС болон Улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгээс 14,313.4 сая төгрөг, "Тогтвортой амьжиргаа-3" төслийн урамшууллаас 333.7, орон нутаг ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэрээс 2,651.3 сая төгрөг, Малын хөлийн тоо толгойн албан татвараас 1,304.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 1,346.3 сая төгрөг нийт 19,076.5 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн 17,729.6 сая төгрөг ОНХС-ийн харилцах дансанд 4,965.0 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ИТХ-аар 22,844.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 523 төсөл, арга хэмжээг баталж үүнээс гэрээ байгуулан ажилласан 17,457.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 415 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 974.8 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээ дутуу, 3,428.6 сая төгрөгийн 78 төсөл арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй буюу төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 73.2 хувьтай байна.

БҮЛЭГ 1

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1.1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэрийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд Булган аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 14,288.4 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 5,221.4, сумдын ОНХС-д 9,007.03 сая төгрөг шилжүүлэг хийхээр батлагдсанаас аймагт 5,013.5, сумдад 8,661.91 сая төгрөгийг олгосон байна. ОНХНС-аас олгохоор батлагдсан дүнгээс аймгийн ОНХС-д 96.02 хувь, Булган сумын ОНХС-д 97.24 хувь, бусад сумдад 96.1 хувийн эх үүсвэр олгогдсон байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс орох эх үүсвэрийг 172.6 сая төгрөгөөр төлөвлөж 215.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 42,6 сая төгрөгөөр илүү орсон байна.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс орох эх үүсвэрийг 418.3 сая төгрөгөөр төлөвлөж 312.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 105.8 сая төгрөгөөр дутуу орсон байна.

Дотоодын ТББ болон гадаадын тусламж хандиваас орох орлогыг 4 сум 333.7 сая төгрөгөөр төлөвлөж бүрэн оруулсан байна.

ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"-ээс орох орлогыг 2,830.8 сая төгрөгөөр төлөвлөж 2,651.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 179.5 сая төгрөгөөр дутуу орсон байна.

Бусад орлогыг 1,288.8 сая төгрөгөөр төлөвлөж 1,346.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 57.5 сая төгрөгөөр илүү орсон байна.

Малын тоо толгойн албан татвараас орох эх үүсвэрийг 1,675.5 сая төгрөгөөр төлөвлөж 1,304.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 371.2 сая төгрөгөөр дутуу орсон байна.

Нийт эх үүсвэрийг 23,058.4 сая төгрөгөөр төлөвлөж 19,076.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 14,228.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 13,675.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.3. Аймгийн ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг олгох шилжүүлгийг сумдад батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2 дахь заалтын дагуу 13,774.6 сая төгрөгийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан аймгийн Засаг даргын захирамжаар аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг батлан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 1 Аймгийн ОНХС-аас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг (сая.төг)

№	Сум, дүүргийн нэр	2024 оны ОНХНС болон улсын төсөв								Нийт эх үүсвэр	
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр		Дотоодын ТББ болон гадаадын тусламж хандив /урамшуулал/			
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	Баян-Агт	309.6	297.6							309.6	297.6
2	Баяннуур	228.1	222.5	4.3	3.2	11.4	8.5			243.8	234.2
3	Бугат	321.4	320.2	12.7	9.5	1.5	1.1			335.6	330.8
4	Булган	552.2	527.2							552.2	527.2
5	Бүрэгхангай	1,000.6	1,000.3	56.1	42.1	127.4	95.5			1,184.1	1,137.9
6	Гурванбулаг	370.6	356.4			1.3	1.0			371.9	357.4
7	Дашинчилэн	664.0	651.0			60.9	45.7			724.9	696.7
8	Могод	320.9	253.3	75.0	56.4			55.2	55.2	451.1	364.9
9	Орхон	1,413.0	1,393.0	8.2	6.2	162.8	122.1			1,584.0	1,521.3
10	Рашаант	189.5	182.1							189.5	182.1
11	Сайхан	384.3	376.1	11.1	6.1	4.8	2.4		-	400.2	384.6
12	Сэлэнгэ	615.6	597.5	5.1	3.8	23.1	17.3			643.8	618.6
13	Тэшиг	831.9	683.0			24.1	18.1	121.6	121.6	977.6	822.7
14	Хангал	143.6	138.2			0.9	0.7			144.5	138.9
15	Хишиг-Өндөр	310.5	162.1	0.1	87.9	0.1	0.1	48.1	48.1	358.8	298.2
16	Хутаг-Өндөр	626.2	492.9	-	-	-	-	108.9	108.9	735.1	601.8
17	Хялганат	218.9	245.3							218.9	245.3
18	Аймаг	5,221.4	5,013.5							5,221.4	5,013.5
		13,722.3	12,912.2	172.6	215.2	418.3	312.5	333.8	333.8	14,647.0	13,773.7

Аймгийн ОНХС-аас олгох санхүүжилтийн шилжүүлгийг 1 сард олгоогүй, дараагийн саруудад нөхөж шилжүүлэн Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4, 41.2.5 дахь заалтуудын дагуу санхүүжүүлсэн байна.

1.1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад 8,983.7 сая төгрөгийн илүү төлөвлөсөн байна.

Аймаг, сум нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох

¹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

аргачлал"-ын 2.2-т заасны дагуу аймаг, сумд нь ОНХС-ийн эх үүсвэрийг 5 төрлийн орлогоор төлөвлөсөн байна.

Хүснэгт №2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая.төг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	2,616.3	11.3
ОНХС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	14,313.3	62.1
Тогтвортой амьжиргаа -3 төсөл урамшуулал	333.7	1.4
Малын тоо толгойн албан татвар	1,675.5	7.3
ИТХ-ийн 60.2.4 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	2,830.8	12.3
Бусад орлого	1,288.8	5.6
Нийт дүн	23,058.4	100.0

ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасан зарим нэр төрөл болон бусад эх үүсвэрээр нэмэгдүүлсэн байна.Тухайлбал:

- Орон нутгийн давсан орлогоос Баяннуур сум 0.19, Бүрэгхангай сум 300.0, Могод сум 175.64, Рашаант сум 424.65, Хангал сум 1,07, Хишиг-Өндөр сум 4.5, Хялганат тосгон 14.0, аймаг 368.70 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх буюу малын хөлийн татварын орлогоос 16 сум 1 тосгон 1,675.45 сая төгрөг
- Булган, Сэлэнгэ, Хишиг-Өндөр сумд болон Хялганат тосгон нь ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдлийг ИТХ-аар батлуулаагүй байна. (Судалгааны хүснэгт-1)

Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшуулал авах нөхцөл хангасан Гурванбулаг, Дашинчилэн, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр зэрэг сумд 333.7 сая төгрөгийн урамшуулал авч эх үүсвэрийг нэмэгдүүлсэн сайн жишээ байна.


Харин бусад сумдын хувьд урамшуулалар ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан, орлогын эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэхэд сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нар идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журам зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.2, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Аймаг, сумын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд сонгууль санал өгөх насны иргэдээс 74,044 иргэн хамрагдан санал өгсөн байна.

График №1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлтэд эзлэх хувийн жин.



Дээрхээс үзэхэд аймаг сумын хэмжээнд нийт 74,044 санал өгснөөс 3,980 саналыг цахим хэлбэрээр авсан нь нийт саналын 5.4 хувийг эзэлж байна.

Үүнээс дүгнэхэд аймаг, сумд цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр иргэдээс санал авах ажлыг ОНХС-ийн журмын 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтад заасан хугацаанд хүртээмжтэй байдлаар алслагдсан багийн иргэдийг хамруулж ажиллахад анхаарч ажиллах.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын түвшинд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан ОНХС-ийн хөрөнгөөр 465 төсөл, арга хэмжээг ИТХ-аар 100 хувь нийцүүлэн баталсан байна.

Харин дээрх 532 төсөл, арга хэмжээнд урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тодорхойлоогүй зөрчил илэрлээ.

1.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх ажлыг хийж хэвшсэнч зарим төсөл, хөтөлбөр арга хэмжээнд төлөвлөхдөө санал аваагүй нь үр ашиггүй хөрөнгө зарцуулах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт №3

Д/д	Аймаг, сумдын нэрс	Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ
		тоо
1	Булган	6

2	Тэшиг	2
3	Хангал	1
4	Хишиг-Өндөр	1
5	Хутаг-Өндөр	1
6	Хялганат	2
	Нийт дүн	13

Дээрхээс үзэхэд зөрчил гаргасан сумд нийт ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 16.8 хувь буюу 856.2 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй байна.

1.2.4. Аймаг, сумдын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр **14,228.4 сая төгрөгийн 532 төсөл**, арга хэмжээг ОНХС-ийн чиг үүрэгт бүрэн нийцүүлэн төлөвлөсөн байна.

Чиг үүргийг салбараар нь авч үзвэл: Сумдын ОНХС

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи чиглэлд 84 төсөл, арга хэмжээний 2,020.9 сая төгрөг,
- Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 99 төсөл, арга хэмжээний 4,907.8 сая төгрөг,
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 82 төсөл, арга хэмжээний 2,709.7 сая төгрөг,
- Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах 9 төсөл, арга хэмжээний 185.2 сая төгрөг,
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах 20 төсөл, арга хэмжээний 454.4 сая төгрөг,
- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх 1 төсөл, арга хэмжээний 36.7 сая төгрөг,
- Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт 2 төсөл, арга хэмжээний 22.7 сая төгрөг,
- Ажлын байр бий болгох 4 төсөл, арга хэмжээний 62.8 сая төгрөг,
- Бэлчээрийн менежментийг сайжруулах 6 төсөл, арга хэмжээний 80.0 сая төгрөг,
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 31 төсөл, арга хэмжээний 568.8 сая төгрөг,
- Гэмт халдлага, гамшгаас хамгаалах 7 төсөл, арга хэмжээний 95.7 сая төгрөг,
- Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх 3 төсөл, арга хэмжээний 37.9 сая төгрөг,
- Малын тэжээлийн ургамал тариалах 1 төсөл, арга хэмжээний 47.8 сая төгрөг,
- Тэжээлийн нөөц бүрдүүлэх 12 төсөл, арга хэмжээний 314.2 сая төгрөг,
- Байгаль орчныг хамгаалах 7 төсөл, арга хэмжээний 92.6 сая төгрөг,
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа 11 төсөл, арга хэмжээний 51.5 сая төгрөг,
- Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 46 төсөл, арга хэмжээний 541.6 сая төгрөг

БҮЛЭГ 2	Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
----------------	--

2.1.1 Аймгийн хэмжээнд 2024 онд нийт 22,441.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 490 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл 77.6 хувьтай бөгөөд 2,824.02 сая төгрөгийн 60 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Нийт 16,771.6 сая төгрөгийн 368 төсөл арга хэмжээнд худалдан авах арга хэмжээг зохион байгуулсан байна. Аймаг болон сумын ИТХ-аар батлагдсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44.4, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.2, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.3 дахь "Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймаг, нийслэлийн түвшинд, сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг сум, дүүргийн түвшинд зохион байгуулна" гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Аймгийн ОНХС-ийн худалдан авах ажиллагаа нь нийт 43 төсөл арга хэмжээ баталснаас 62.5 хувь нь нээлттэй тендер, 37.5 хувь нь харьцуулалтын аргаар шалгарч гэрээг байгуулсан байна.

Хүснэгт№ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа

<i>/сая төгрөгөөр/</i>											
№	Аймаг, сум	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ-ний		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах		Олон нийтийн оролцоотой худалдан авалт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС	16	6,618.4	10	4,037.0	6	378.0	0	0	0	0
2	Сумдын ОНХС	352	12,356.5	36	2,919.9	83	5,209.1	182	2,679.7	9	117.7
	Нийт	368	18,974.9	46	6,956.9	89	5,587.1	182	2,679.7	9	117.7

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 368 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний 10.2 хувь буюу 36 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 23.5 хувь буюу 83 ажлыг тендер шалгаруулалтын харьцуулалтын журмаар, 0.2 хувь буюу 9 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 51.7 хувь буюу 182 ажлыг шууд худалдан авчээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1, 31.1-д заасны дагуу нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

2.1.2 Тайланд онд аймаг, сумдын ИТХ-аар 22,383.9 сая төгрөгийн 490 ажил батлагдаж 17,380.8 сая төгрөгийн 403 ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулж бүрэн хэрэгжсэнээс 128.3 сая төгрөгийн 7 ажлын санхүүжилтийг дутуу олгосон, дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь 1,287.8 сая төгрөгийн 27 ажлын гэрээ байгуулж гүйцэтгэлээр 602.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож байна.

ИТХ-р батлагдсан ТАХ-ээс огт хэрэгжээгүй 2,824.02 сая төгрөгийн 73 ТАХ үлдсэн нь малын тоо толгойн албан татвар бүрэн төвлөрөөгүй, улирлын чанартай, сонгон шалгаруулалт зарласан боловч оролцогч иргэн, ААН-ээс материал ирүүлээгүй нь тендер шалгаруулалтыг зохион байгуулах цаг хугацаа, нөөцийг харгалзалгүй олон ажил төлөвлөх, ХАА-г зохион байгуулахдаа улирлын болон онцлог шинж чанартай ажлуудыг хугацаа алдаж тендер сонгон шалгаруулалт зарласан, төсвийг зах зээлийн үнийн дүнгээс бага төлөвлөсөн зэргээс шалтгаалан тухайн онд хэрэгжээгүй, үр дүнгүй цаг хугацаа алдсан байна.

Хүснэгт № ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт /сая төгрөгөөр/

№	Аймаг, сум	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	дүн
1	Аймгийн ОНХС	21	7,572.9	21	7,365.3	16	6,618.4	1	8.9	4	738.0
2	Сумдын дүн	469	14,868.9	391	11,937.7	382	10,762.5	26	1,278.8	69	2,086.02
	нийт дүн	490	22,441.9	412	19,380.8	398	17,380.9	27	1,287.7	73	2,824.02

ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулаагүй байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хөрөнгийг зарцуулахтай холбоотойгоор бусад хууль тогтоомж зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- 100 жилийн ойн баяр наадмын талбайн байгууламж /цэнгэлдэх хүрээлэн/ шинээр барих 300.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг /15 хоног/, био 00 барих 50.0 сая төгрөгийн өртөгтэй /8 хоног/, бод малын эрүүлжүүлэх хашаа 8.0 сая төгрөгийн өртөгтэй /121 хоног/ 3 төсөл арга хэмжээнд алданги үүссэнг тооцоогүй. (Сайхан сум)
- Сумын төвийн төв замын гэрэлтүүлэг тавих, хуучныг нь засварлах 50.0 сая төгрөгийн өртөгтэй /29 хоног/, Бэлчээрийн 4ш худаг гаргах 108.0 сая төгрөгийн өртөгтэй /29 хоног/, Зам даваа засах Тээл голын гүүр засварлах 16.0 сая төгрөг /19 хоног/ 3 төсөл арга хэмжээний алданги тооцоогүй. (Хутаг-Өндөр сум)
- Тэшиг дулааны шугам зургийн дагуу гүйцэтгээгүй
- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг ИТХ болон дотоод болон хөндлөнгийн хяналт хийгээгүй. /10 сум/

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

2.2.1 Булган аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгон болон аймгийн хэмжээнд ОНХС-гийн 22,441.9 сая төгрөгийн 490 төсөл арга хэмжээг ИТХ-аараа баталсан байна. Үүнээс 2024 онд 2,824.02 сая төгрөгийн 73 төсөл арга хэмжээ нь огт хэрэгжүүлээгүй байгаа нь ОНХС-ийн үр ашиг, үр дүнгээс бууруулж байна.

- Баян-Агт сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 249.4 сая төгрөгийн 17 ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Баяннуур сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 128.5 сая төгрөгийн 5 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Бугат сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 63.0 сая төгрөгийн 3 ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Бүрэгхангай сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 537.0 сая төгрөгийн 9 ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Дашинчилэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 137.2 сая төгрөгийн 6 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Могод сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 68.5 сая төгрөгийн 4 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Орхон сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 453.5 сая төгрөгийн 8 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Рашаант сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 5.0 сая төгрөгийн 1 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Сайхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 16.7 сая төгрөгийн 2 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Сэлэнгэ сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 38.5 сая төгрөгийн 3 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Хангал сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 2.0 сая төгрөгийн 1 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Хишиг-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 95.9 сая төгрөгийн 4 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Хутаг-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 265.7 сая төгрөгийн 5 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Хялганат тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр баталсан 25.0 сая төгрөгийн 1 ТАХ-ээг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр батлагдсан 1,941.0 сая төгрөгийн 4 ТАХ тус тус хэрэгжээгүй байгаа нь ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт үр дүн, үр ашгийн үзүүлэлтийг бууруулж байна.

Сайхан сум ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд төлөвлөн хэрэгжүүлэх ажлуудыг эрэмбэлж, нэгдсэн жагсаалт боловсруулах ажлын хэсгийг томилоогүй, захирамж гаргаагүй нь Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6.1² дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Сумдын түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх үе шатны ажлын хэсэг байгуулагдаагүй, баг хороодоос ирсэн саналыг эрэмбэлж нэгтгэхдээ журмын 6.4³ дэх заалтын үзүүлэлтүүд, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт, хүрэх дүн болон бусад тооцооллыг хийсэн баримт материал бүрдүүлээгүй. Тухайлбал:

² 6.1. Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна.

³ 6.4. Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

- Тайлант онд 543.7 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлахдаа хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн Засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй зөрчил илэрлээ. (Сайхан сум)
- Хүүхдийн тоглоомын талбайн тоглоомыг шинээр хийсэн боловч арчилгаа хамгаалалт муутай. (Булган сум)
- ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх үе шатны ажлын хэсэг байгуулагдаагүй, баг хороодоос ирсэн саналыг эрэмбэлж нэгтгэхдээ журмын 6.4 дэх заалтын үзүүлэлтүүд, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргасан эсэх баримт материал бүрдүүлээгүй байна. (Сайхан сум, Баян-Агт сум, Хутаг-Өндөр сум)
- Цахимаар авсан иргэдийн саналыг журмын хавсралт 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэж баталгаажуулаагүй. Иргэдээс авсан цаасан суурьтай иргэдийн саналын хуудас нэгтгэл баримт материал байхгүй. (Сайхан сум)

Аймаг, сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.¹⁴, 14 дүгээр зүйлийн 14.2.3⁵, 14.3⁶, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.3.4⁷ дахь заалтын дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин үр дүнг бодитой тодорхойлоогүй, хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төслийн төсөвт өртгийн харьцааг тооцсон тоо мэдээлэл байхгүй, тодорхойлсон гэх боловч холбогдох хангалттай зохистой нотлох баримтгүй байна.

Малын тоо толгойн албан татварын зарцуулалт

Тайлант онд МТТАТ-аар 1,270.01 сая төгрөгөөр 88 ажил хийхээр төлөвлөж сумдын ИТХ-аар баталснаас 1,039.5 сая төгрөгийн ажил хийгдсэн нь нийт ажлын 81.8 хувь нь хэрэгжсэн байна.

ОНХС-ийн дансанд гүйцэтгэлээр МТТАТ 1,414.02 сая төгрөг төвлөрүүлсэн боловч малчдад чиглэсэн ажилд 1,039.5 сая төгрөг зарцуулсан нь 374.5 сая төгрөг дутуу зарцуулсан байна. МТТАТ-г орлогыг өмнөх онтой харьцуулахад 121.8 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн байна.

Сумын түвшинд үзэхэд татвар төвлөрүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалж татварын төлөвлөгөө тасардаг мөн ОНХС-ийн дансанд төвлөрүүлсэн татварын санхүүжилтийг бүрэн зарцуулахгүй байгаа нь татвар төлсөн малчид төрийн үйлчилгээг дутмаг авч байна.

Дүрслэл №... Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ангилал

⁴ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁵ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

⁶ 14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

⁷ 7.3.4.Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцаа.

Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн ТАХ




2.2.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн нийт 6,707.6 сая төгрөгийн 43 ажил байгаагаас Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологитой холбоотой 4,178.4 сая төгрөгийн 7 ТАХ, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээтэй холбоотой төрлийн 594.2 сая төгрөгийн 3 ТАХ, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахтай холбоотой 1,437.4 сая төгрөгийн 6 ТАХ, аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахтай холбоотой 407.7 сая төгрөгийн 26 ТАХ, бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэхтэй холбоотой 89.9 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ зэрэг ажил хийгдсэн нь аймаг, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

Аймаг, сумын хэмжээнд ИТХ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 "Ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу тус журмын 5.10, 5.12, 5.13 батлуулсан төсөл арга хэмжээ нь олон нийтийн саналаар эрэмбэлэгдэж батлагддаг.

Сум, хорооны Засаг дарга ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлсэн байна. Үүнд: Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологитой холбоотой 2,020.9 сая төгрөгийн 84 ТАХ, Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээтэй холбоотой 4,907.8 сая төгрөгийн 99 ТАХ, Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахтай холбоотой 2,709.7 сая төгрөгийн 82 ТАХ, Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахтай холбоотой 185.2 сая төгрөгийн 9 ТАХ, Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахтай холбоотой 454.4 сая төгрөгийн 20 ТАХ, Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн

чанар, үүлдвэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэхтэй холбоотой 36.7 сая төгрөгийн 1 ТАХ, Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалтад 22.7 сая төгрөгийн 2 ТАХ, Ажлын байр бий болгохтой холбоотой 62.8 сая төгрөгийн 4 ТАХ, Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр 1,830.1 сая төгрөгийн 124 ТАХ зэрэг ажил хийгдсэн нь сум, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.



2.3.1 ОНХС-аар 2024 онд бүрэн хэрэгжсэн 404 төсөл арга хэмжээнээс зориулалтын дагуу ашиглаж байгаа 402 төсөл арга хэмжээ буюу 99 хувийг зориулалтын дагуу ашиглаж 2 төсөл арга хэмжээг ашиглаагүй үр дүн муутай байна.



1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 3 багт бод малын эрүүлжүүлэх хашааг 8.0 сая төгрөгөөр хийхээр шууд гэрээ байгуулж урьдчилгаа 6.0 сая төгрөгийн авч үлдсэн 2.0 сая төгрөгийг ажил хүлээлгэн өгөхөд олгохоор байсан боловч нэг хашааг хийгээд ашиглаагүй дутуу 2 хашаа хийгдээгүй гэрээний хугацаанаас 121 хоног хэтэрсэн төсөл арга хэмжээ байна. (Сайхан сум)
2. Хутаг-Өндөр суманд бэлчээрийн худаг 4 багт нийт 108.0 сая төгрөгийн өртөгтэй гаргасан боловч Уньт багт хийгдсэн худгийг үзэхэд ашиглаагүй байх магадлалтай, өвөлжөө хаваржааны газар гаргасан боловч ойр орчимдоо нэг айлын өвөлжөөний хашаатай, уулын аманд байгаа нь үр ашиг муутай байрлалд худаг гаргасан байна гэж үзлээ.
3. Ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэл дэмжих төсөл хөтөлбөрийн арга хэмжээний 17.3 сая төгрөгийг өрхийн амьжиргаа дэмжих зорилгоор төмс 8,000 кг, сонгино 600 кг авч сумын иргэдэд тарааж өгсөн ажил хийгдсэн нь үр дүн муутай ажил хийгдсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн. (Сэлэнгэ сум)

2.3.2 ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн ажлуудыг бүртгэлд тусгаагүй дараах зөрчил илэрсэн. Тухайлбал

- Бүрээхангай сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 38.2 сая төгрөгийн тохижилтын 2 ажлыг данс бүртгэлд тусгаагүй
- Дашинчилэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 204.6 сая төгрөгийн 7 ТАХ-ээг данс бүртгэлд тусгаагүй.
- Орхон сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 309.6 сая төгрөгийн 13 ТАХ-ээг данс бүртгэлд тусгаагүй.
- Рашаант сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 164.0 сая төгрөгийн 11 ТАХ-ээг данс бүртгэлд тусгаагүй.
- Тэшиг сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 428.9 сая төгрөгийн өртөгтэй 3 ТАХ-г бүртгэл тайланд тусгаагүй байна. (1. “Ахуй үйлчилгээ, Хүний хөгжлийн төв, технологийн кабинетыг дулааны шугамд холбох” ТАХ-г “Тэшиг-Ус” ОНӨААТГГ орлого авах байсан боловч Худалдан авах ажиллагааны газарт иргэнээс гомдол гарч худалдан авах ажиллагааг дахин шалгах хүсэлт гаргасан байна. 2. “Хүүхдийн тоглоомын талбай барих” Эцсийн байдлаар хүлээж аваагүй үлдэгдэл санхүүжилт олгогдоогүй.)
- Хутаг-өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 17.8 сая төгрөгийн 1 ТАХ-ээг данс бүртгэлд тусгаагүй.
- Хишиг-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 12.9 сая төгрөгийн 1 ТАХ-ээг данс бүртгэлд тусгаагүй. (хөрөнгийн шинж чанар муу)
- Баян-Агт сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2.8 сая төгрөгийн вакциныг данс бүртгэлд тусгаагүйг санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн байна.

3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих аймаг, сумдын ИТХ-ын хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

3.1.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

Аймгийн болон 9 сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд Баян-Агт, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хишиг-Өндөр сумдын ИТХ-аас хяналтыг хэрэгжүүлсэн, бусад сумдын ИТХ хяналтын ажлыг хийгээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/*

Харин хяналт хэрэгжүүлсэн сумдын ИТХ-ын дэргэдэх хороод болон хяналтын бүлэг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч, эрэмбэлсэн эсэх, багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлыг хяналтад хамруулалгүйгээр зөвхөн хэрэгжилт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан эсэхийг хамруулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум нь хэрэгжүүлсэн, бусад сумдууд огт хэрэгжүүлээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/*

Тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт огт хийгдээгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй, 2024 онд хийхээр төлөвлөснийг Төрийн аудитын байгууллага аудитыг эхлүүлсэн учир СХДАА нь төлөвлөгөөнд тусгагдсан ОНХС-д хийх хяналт шалгалтыг давхардуулахгүй гэсэн үүднээс цуцалсан байна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Алтаргана наадам зохион байгуулсан ажилп аудит хийсэн байна.

3.1.2 Булган аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг Баян-Агт, Бугат, Булган, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдууд бүрэн хэрэгжүүлсэн, Баяннуур, Гурванбулаг, Сэлэнгэ сумдууд огт хэрэгжүүлээгүй байна. Аймаг болон Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Сайхан, Тэшиг, Хангал сумдууд, Хялганат тосгон 53 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/*

3.1.3 Булган аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2024 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, аймаг, сумдын дүнгээр нийт 9 төлбөрийн акт 25.1 сая төгрөгөөс 8 төлбөрийн акт 24.0 сая төгрөгийг барагдуулж биелэлт 80.0 хувьтай, 4 албан шаардлага 308.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 7-аас харах/

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг 8 сум, 1 тосгон журмын дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2⁸, 9.3⁹ дахь заалтуудын дагуу ОНХС-ийн 2024 оны хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т Баяннуур, Бугат, Булган, Гурванбулаг, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг сумууд болон Хялганат тосгон гэсэн 8 сум 1 тосгон хүргүүлээгүй байна.

Аймаг, сумын ЗДТГ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.5¹⁰ дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.2.2 Аймаг, сумын ЗДТГ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.12¹¹ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон дараах 868.3 сая төгрөгийн 26 хөрөнгийг ашиглагч байгууллагууд санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй байна. Үүнд: Дашинчилэн сум нийт 37 ТАХ батлуулж хэрэгжүүлсэн боловч 20 ажлыг бүртгэлд тусгаагүй, Бүрэгхангай сумын ЕБС-тай холбоотой 2 ажлыг хүлээж аваагүй, бүртгэлд тусгаагүй, Орхон суманд бүртгэлд тусгаагүй 2 ТАХ, Тэшиг суманд хүлээж аваагүй бүртгэлд тусгаагүй 2 ТАХ, Сэлэнгэ суманд цагдаагийн замын тэмдэг тэмдэглэгээг бүртгэлд тусгаагүй зэрэг ажлууд байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа....-аас харах/

3.2.3 Аудитын явцад Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт,

⁸ 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

⁹ 9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, 7 / 18 дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

¹⁰ 9.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

¹¹ 9.12.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад ОНХС-гийн удирдлага мэдээллийн системд 2024 онд дутуу оруулсан 1,950.9 сая төгрөгийн 11 ТАХ, огт оруулаагүй 5,977.3 сая төгрөгийн 39 ТАХ байгаа нь мэдээллийг бүрэн оруулж иргэн олон нийтэд үнэн зөв мэдээллийг хүргэхээр байгаа боловч ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3.9, 10.2.1¹², 10.3.1¹³ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Удирдлага мэдээллийн системийн “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” цэсээр аймаг, сумдын 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнг үнэлж дүгнээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтуудыг зөрчин аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх явцын мэдээллийг удирдлага мэдээллийн системд оруулаагүй байхад тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг гүйцэтгэсэн алдаа зөрчил давтагдсаар байна.

3.2.4 Аймгийн ОНХС болон 16 сум, 1 тосгоны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж шалгасан байна. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад Могод, Дашинчилэн сум зэрэг сумдад зөрчлийг арилгах албан шаардлага өгч Рашаант суманд зөвлөмж хүргүүлэн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэсэн байна.

Өмнөх аудитаар аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарт ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁴ заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг давтан гаргасаар байна.

¹² 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

¹³ 10.3.1.Баг, хорооны Засаг дарга, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн УМС-ийн төлөвлөлт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 6 дугаар сард багтаан бүрэн оруулж, өөрийн ажлын хүрээнд шаардлагатай мэдээллийг гарган авч ашиглана;

¹⁴ 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад нэмэгдүүлж төлөвлөсөн, төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний иргэдийн саналыг ОНХС-гийн журмын санал авах маягтын дагуу цахимаар болон цаасаар авч журмын дагуу эрэмбэлсэн боловч зарим сумдууд иргэдийн саналгүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ ажлын хэсэг томилдоггүй, хууль, журмыг баримталдаггүй, баримт материал бүрдүүлдэггүй, тооцоолол ОНХС-гийн дансанд төвлөрүүлсэн малын хөлийн татварын бүрэн зарцуулдаггүй, ИТХ-аар батлагдсан ажлуудыг дутуу хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан *“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”*-ыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээг ХБТХОХ-ээс хийгээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн өгсөн эрэмбэлэгдсэн саналын дагуу шаардлагатай төсөл арга хэмжээ хэрэгжиж ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.

ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд ИТХ, дотоод аудит, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлүүлэх, хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргуулж нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээс бүрэн бүрдүүлэхээр төлөвлөх, хандив, тусламжийн болон Малийн тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-ийн дансанд бүрэн төвлөрүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, уг татвараар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээллийг оруулах, хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. ОНХС-ийн аудитаар гарч буй зөрчлийг арилгах үүднээс аймаг, сумдын холбогдох албаны хүмүүсийг сургалт, болон мэдээллээр хангаж ажиллах.
2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлох.
3. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлүүлэх, хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргуулж нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж байх
4. Аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах

Бүрэгхангай сумын Засаг даргад

5. "ЕБС-ийн дотуур байрны гадна талбайг тохижуулах", "ЕБС-ийн хичээлийн байрны гадна талбайг бетондох" **зэрэг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан гэрээний хугацаа хэтэрсэн хоногт алданг тооцох**

Орхон сумын Засаг даргад

6. "6 цэгт эко 00-той болх", "Ахмадын цэцэрлэгт хүрээлэн", "Хүүхдийн тоглоомын талбай засварлах", Жижиг голд гүүр тавих", "Хавчиг хадны боргио хаших" **зэрэг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан гэрээний хугацаа хэтэрсэн хоногт алданг тооцох**

Сайхан сумын Засаг даргад

7. Сумын 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор баяр наадмын талбай барихад 300.0 сая төгрөгийн төсөв баталж гүйцэтгэгч "И ЭС БИ АЙ" ХХК-руу 275.01 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Тус гүйцэтгэгч ажил гүйцэтгэх хугацааг сунгасан боловч 15 хоногоор хугацааг хэтрүүлж хүлээлгэн өгсөн тул гэрээнд заасан 0.5 хувийн алдангийг тооцож авах.

8. Сумын ойтой холбогдуулан био 00 барих ТАХ-д 50.0 сая төгрөгийг төсөвлөж гэрээгээр ОНХС-аас 50.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээнд заасан хугацаанаас 8 хоног хэтэрсэн тул алдангийг тооцож авах.

9. Бод мал эрүүлжүүлэх хашааг 3 багт хийхээр 8.0 сая төгрөгийн төсөв баталсан боловч гүйцэтгэгч иргэнд 6.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч гэрээний хугацаанд бод малын 1 хашаа хийж 2 хашааг хугацаандаа хийгээгүй 121 хоногийн хэтэрсэн тул алдангийг тооцож авах.

Хутаг-Өндөр сумын Засаг даргад

10. Сумын төв зам дагуу гэрлийг сольж, засварласан боловч гэрээнд заасан хугацаанд хүлээлгэж өгөөгүй 29 хоног хэтэрсэн боловч алданги тооцоогүй тул гэрээнд заасан 0.1 хуваариар алдангийг тооцох.

11. Суманд бэлчээрийн худаг 4 багт нийт 108,000.0 мянган төгрөгийн өртөгтэй гаргасан боловч гэрээнд заасан хугацаанаас 29 хоног хоцроож хүлээлгэн өгсөн алдангийг тооцож гэрээний үүргийг хангуулах.

12. Хутаг-Өндөр сумын тээл багын Тээлийн голын гүүр засварлахаар 1,600.0 мянган төгрөгийг төсөвлөсөн боловч гэрээний хугацаанаас 19 хоногоор хоцроож хүлээлгэж өгсөн тул алдангийг тооцож авах.